*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, хошууч Ч.Баатарсүх*

# ҮЕРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАХ СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Энэхүү нийтплэлээр онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд нэн тэргүүнд тулгамдаж байгаа асуудал нъ үер усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар хөндөж тавихыг зорилоо.*

***Түлхүүр*** *үг. Онцгой байдлын алба, удирдах албан тушаалтаны шийдвэр, гамшгаас хамгаалах бэлэн байдал, үер усны аюул.*

Аливаа улс нийгэмд, удирдлага тодорхой эрх мэдэл эдэлж чухал үүрэг гүйцэтгэнэ. Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх албаны удирдлага байнга амь өрссөн нөхцөлд үүрэг гүйцэтгээд зогсохгүй, бусдын амь насыг хамгааалах талаар шийдвэр гаргадаг. Удирдлагад тохиолддог зарим хүчин зүйлийг авч үзье:

- Шийдвэр гаргах мэдээ, мэдээллээр удирдлага дутагдах, эсвэл удирдлагад буруу мэдээлэл танилцуулах;
- Удирдлагаас доод тушаалын чухал мэргэжлийн хүмүүст заавар, зөвөлгөө өгөх, тэдэнд яаралтай удирдамж явуулах нөхцлийг хангах холбооны хэрэгсэл, гэмтэх, ажилгүй болох;
- Үерийн аюулаас хамгаалах хүнд хэцүү байдал нь удирдлагаас өөрийнхөө үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход бэрхшээл учруулах;
- Аврах, ажил явуулах шаардлагатай мэргэжилтэн, багаж хэрэгсэл, машин техник зэрэг нөөц хүч хэрэгсэл, хохирох, үерийн далан сэтрэх, гэх мэт олон хүчин зүйлүүдийг дурьдаж болох юм. Тухайн онцлог нөхцөл байдлаас хамаарч гамшгийн үед удирдлагад нөлөөлж бусад олон хүчин зүйл байх нь мэдээж юм.

Тэгвэл Сэлэнгэ аймгийн үерийн далангын ашиглалтын хугацаа түүнд тавигдах хяналт өнөөдөр ямар байна вэ?.

- Олон далан эрт үед байгуулагдсан учраас сэв суусан, цоорхой гарсан боловч, нүдэнд үл өртөх морин шоргоолжны үүр их бий болсон нь даланг нуралтанд хүргэж болно.
- Үерийн үед голын хөдөлгөөний чиглэлийн өөрчлөлт далангын элэгдэлд хүргэж болно. Харин далангын элэгдэлээс хамгаалах инженерийн хамгаалалт маш өндөр өртөгтэй, инженерийн төвөгтэй арга хэмжээ юм.

- Далан дахь үсрийн үед усын хяналттайгаар нэвтрүүлэх олон нүх цоорхой бохирдож, ажиллахгүй болдог.
- Зарим далан хэтэрхий намхан бөгөөд хүчтэй хар салхи шуургыг барьж чаддаггүй.
- Хууль эрх зүйн хэм хэмжээ байгаа ч далангын ойролцоо барилга барих үед ялангуяа хүн амын нягтрал ихтэй газарт илээр олон зөрчил гарч байна.
- Даланг голын түвшингийн ерөнхий ихсэлт болон бохирдолд хүргэдэг, мөн байгалийн бордоо талбайд нэвтрэхийг хааж, газрын үржил шимт чанарыг бууруулах, хиймэл бордоо хэрэнлэх нь тухайн газрын экосистемийг муутгадаг аюултай. Сэлэнгэ аймагт тохиолдсон үер усны аюулаас үүдэн гарсан зарим томоохон тохиолдолыг дурьдвал:

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт хүчтэй аадар бороо, мөндөр орсны улмаас хур тунадасны хэмжээ 61 мм, мөндрийн диаметр 4-5 см орчим байсан. Гамшгийн нөхцөл байдлаас үүдэн гол ус үерлэж эрчим хүч, харилцаа холбооны шугам сүлжээ, төсвийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн барилга байгууламж хүчтэй эвдэрч сүйтэн, үр тариа, хүнсний ногооны талбай, ой мод мөндөрт цохиулан, мал амьтан үрэгдэж, ард иргэд эрүүл мэндээр хохирч, Түшиг сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэг, Соёлын төв, цагдаагийн байр зэрэг 8 төсвийн байгууллагын 4310,3м$^2$ модон хийц, төмөр шипрэн бүтэц бүхий дээвэр нуржк, 291 цонх хагарсан. 269 айл өрх өртсөнөөс 204 айл өрхийн цонх хагарч, 183 айлын 13550,6м$^2$ дээвэр эвдэрч хуударсан. 15 айлын гэр нурсан. 24 хүн гэмтэж бэртсэн. 74 машины цонх хагарсан. 14 өрхийн 4 төрлийн нийт 104 мал, амьтан хорогдсон. Цахилгаан дамжуулах 10 кв-ийн агаарын шугамын 2 тулгуур, 04.022-ын 4 тулгуур унаж 71 тулгуур хазайсан. 2 трансформаторт гэмтэл гарч агаарын шугам тасран сумын хэмжээгээр цахилгаангүй болсон. Байгаль орчинд хүчтэй хохирол учруулж нарс 41, шинэс 300 мод унасан, хугарсан, үндэсээрээ булгарсан, модны шилүүс гөвөгдсөн, хар мод цууралттай болсон.

Иймд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээг нийт ард иргэдэд ухамсарлуулан ойлгуулах бодит байдал дээр сургалт сурталчилгааг хийхэд машин техник, бензин тос зардал мөнгө, тухайн жилийн төсөвт тусгагдсан хөрөнгө мөнгө хүрэлцэхгүй, олон жил болсон машин техникийн эвдрэл гэмтэл, сэлбэг хэрэгсэл зэргээс хамааран шаардлагатай асуудлууд нэн тэргүүнд тулгамдаад байна.

**Үер нь дараах учир шалтгааны улмаас үүсдэг байна:**

Үерт хүргэдэг хамгийн гол шалтгаан нь их усархаг бороо байдаг. Бороо улиралаас шалтгаалан их хэмжээний нутаг дэвсгэрийг, эсвэл хар салхийг дагалдан багахаан нутаг дэвсгэрийг хамарч орж болно. Зарим үед ЭльНиньогийн үзэгдэл буюу хүчтэй урсгал зэрэг атмосперийн ба далайн үзэгдлүүдтэй холбоотой байдаг. Цас хайлах нь үер болох бас шалтгаан болдог.

**Үерийг төрлүүдээр нь авч үзвэл:**

1. Гэнэтийн үер
2. Голын үер
3. Эрэг орчмын үер гэж 3 хуваадаг

**Гэнэтийн үер гэдэг нь** хүчтэй аадрын үүл, хүчтэй аянга ба цахилгаан, халуун орны хар салхи эсвэл хүйтэн агаарын фронт, дагалдсан усархаг бороо эхэлснээс 6 цагийн дотор болж байгаа үерийг хэлнэ. Үерийн энэ төрлийн үед боломжтой бол орон нутгийн зүгээс шуурхай урьдчилан анхааруулж, аюулыг бууруулах шаардлагатай[1]. Хүчтэй үер нь ихэвчлэн чийгшилтэнд ханасан, түүнийг цаашид шингээх чадваргүй болсон гэзэр нутгаас бууж байгаа усны урсгалын үр дүн юм. Түргэн, гэнэтийн үерийн өөр нэг шалтгаан нь усны далан задрах, мөсний цөн түрэх ба хайлах, түүнчлэн голын ус эргээсээ халих, хүчтэй хур тунадас орох магадлалтай, усны урсгал нарийн хавцлаар буух, тэгш, хатуу газар нутагт илүү аюултай байдаг.

**Голын үер нь** хур тунадас элбэгших эсвэл өвөл хуримтлагдсан цас хайлах, зарим тохиолдолд энэ хоёрын хавсарсан үзэгдэлтэй холбоотой. Энэ төрлийн үер нь гэнэтийн үерээс аажим, шатлаж нэмэгддэг, ихэнхдээ улиралын байдаг, хэдэн өдөр, хэдэн долоон хоногоор үргэлжилдэгээрээ ялгаатай.

**Эрэг орчмын үер нь** халуун орны нар салхитай / заримдаа тэднийг ураган, тайфун гэж нэрлэдэг/ холбоотой үүсдэг. Их усархаг борооны хүчтэй үер нь заримдаа эрэг орчмын хүчтнй салхи, шуурнаар улам нэмэгддэг. Хүчтэй татлага, түрлэг, цунами, далайн хүчтэй давалгааны улмаас хуурай газар далайн давстай усанд автдаг, их усархаг хур тунадас нь эрэг орчмын бүсийн үерийг голын үерийнх шиг нэмэгдүүлж болно.

Хохиролын эрсдэлийг бууруулахад цаг үеийн арга хэмжээнд орц ба цонхнуудыг хаах болон усны хөдөлгөөнийг зогсоох элстэй шуудай ашиглах, мөн урт хугацааны арга хэмжээнд барилга байгууламжийг үерийн болзошгүй түвшинөөс дээш өргөх зэрэг аюулд тэсвэртэй загвар

[1] Ник Картер “гамшгийн менежмент” орчуулсан Ш.Болдбаатар УБ„ 2005

хийцийг хэрэглэх асуудлыг хамааруулна. Судалгаанаас үзэхэд урьдчилан мэдэгдэх системээр үерийн хохирлыг 6-гаас 40%-иар бууруулж чаддаг байна. Үерийн урьдчилсан мэдээ, зарлан мэдээлэл болон бэлэн байдлын системийн үндсийг хангадаг үерийг илрүүлэх систем нь хур тунадас болон үерийн хөгжлийг ажигладаг сайн дурынхныг багтаасан өртөг багатай системүүдээс эхлээд хэмжигч багажийн нарийн хэмжээ, цахим тооцооллын загварыг хамардаг.

Олон нийтийн бэлэн байдалд усанд автдаг газрын хүн ам ихэвчлэн үертэй тэмцдэг уламжлалт аргуудыг мэддэг. Хүн ам нутаг дэвсгэрийн ихэнх нь үерийн аюулд нэрвэгддэг Сэлэнгэ аймгийн хувьд аюулыг бууруулах бага шиг арга хэмжээнүүдийн үед ч орон нутгийн зүгээс бүх зардалыг гаргахад ихээхэн хүндрэлтэй байдаг. Үерээс хамгаалах зарим аргуудыг орон нутгйип түвшинд нарийн боловсруулж, хэрэглэж болох ба цаашид гадны дэмжлэгтэйгээр улам сайжруулах шаардлагатай байна.

Сэлэнгэ аймгийн хэмжэээнд гарч байгаа гамшиг осол, үерийн улмаас гарч байгаа хохирол, 2012 онд гарсан эх хүү хоёрын эндэгдэл, зэрэг олон айдас түгшээмээр асуудал ар араасаа гарч байна. Ер нь аливаа асуудал нь заавал эзэн шалтгаантай байдаг боловч тухайн үед шаардлага тавьж анхааруулга өгсөөр байтал өөрсдийн хэнэггүй, тоомжиргүй зангаасаа болж амь насаа алдах, тухайн үед дуудлага өгөхдөө цаг хугацаа алдах, зэрэг тоочоод байвал зовлон бэрхшээл их л гарч ирнэ. Улс орны хэмжээнд ч тэр орон нутгийг удирдах захиргааны байгууллагууд нь гарсан осол эндэгдэлийг тухай бүр нь хурдан шуурхай, оновчтой зөв шийдвэр гаргаж, цаг хугацаа алдахгүй шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд уулын мөс хайлах, цөн түрэх, аадар бороо олон хоногийн давтамжтайгаар орох голын усны түвшин нэмэгдэх зэрэг үерийн аюул үүсэхэд голын эрэг дагуу байрласан айл өрхийг даруй нүүлгэн шилжүүлэх, орон нутгийн байгууллагууд урьдчилсан арга хэмжээг зохих түвшинд авч мэргэжлийн ангиудыг нэн даруй зарлан мэдээлэх хэрэгслээр дамжуулан албадыг цуглуулан шаардлагатай арга хэмжээг авна.

Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, тулгамдаж буй асуудлын талаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд гарч байсан томоохон хэмжээний үер, усны ослын талаар судалгааны ажил явуулахад сүүлийн таван жилд гарч байгаа нийт гамшиг ослын дийлэнх хувийг үерийн асуудал эзэлж байна. Аймаг орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, түүнд тусгагдсан үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, болзошгүй

ослын үед богино хугацаанд мэдээ мэдээллийг үнэн зөв дамжуулан мэргэжлийн ангийг цаг алдахгүй цуглуулах шаардлагатай байна.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө, түүнд тусгагдсан үерийн үед авах арга хэмжээний талаар орон нутагт улиралын чанартай гэрээт пост ажилуулан сум дундын тамгын дарга нартай харилцан уялдаа холбоотой ажиллаж, тухайн албан хаагч нь 14 хоногийн хугацаанд ажиллахдаа сургалт. сурталчилгаа зохон байгуулан биет байдал дээр үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, гарч байгаа хохиролын хэмжээ зэргийг ард иргэдэд ухуулан таниулах ажил нь тодорхой хэмжээнд үр дүнгээ өгсөн байна. Үерийн аюулаас урьдчилан сэргнйлэх ажлын хүрээнд аймгийн засаг даргын захирамж, онцгой байдлын газраас гаргасан зөвлөмжийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан иргэд, ахуй нэгж байгууллагад түргэн хүргэх шаардлагатай байна.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн*
*821 дүгээр дамжааны суралцагч,*
*дэд хурандаа М.Буянбаатар*

## БОЛЗОШГҮЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ҮЕД ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Энэхүү нийтлэлээрээ Улаанбаатар хотод үүсч болзошгүй аюулт үзэгдэл, ослын үеийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах асуудлыг хөндөж тавихыг зорилоо.*

***Түлхүүр*** *үг. Болзошгүй аюулт үзэгдэл, осол, шуурхай удирдлага, зохицуулалт.*

Монгол Улсад гамшгаас хамгаалах шинэ эрх зүйн орчин, шинэ тогтолцоо бий болоод удаагүй ч гамшигтай тэмцэх талаар олон талт үйл ажиллагаа амжилттай явагдсаар ирлээ.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжлийг даган хотжилт, үйлдвэрлэл, үйлчилгээ өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангах хүрээнд өргөжин тэлж, хүн амын хэт их төвлөрөл, ажилгүйдэл, өрхийн орлогоос хамааралтай ядуурал бий болж, үүний улмаас аюулт үзэгдэл, ослын тоо, давтамж жил ирэх тусам нэмэгдэж байршил, байр зүйн хувьд нийслэл хот маань ачааллаа даахаа больжээ. Улаанбаатар хотын оршин суугчдын Үндсэн хуулиар олгогдсон эрх, аюулгүй ажиллаж, амьдрах баталгааг хангах, тэдгээрт төрийн ажил, үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэж ажиллах чиг үүрэгтэй онцгой байдлын байгууллагын нийслэлийн Аврах анги, Гал унтраах, аврах ангиуд шуурхай дуудлагаар ажиллах үед тээврийн хэрэгслийн зорчих хэсэг, гарц,

гэр хорооллын хаягжилт тодорхойгүй, зарим хэсэгт даваа гүвээтэй, шавар намаг ихтэй, халтиргаа гулгаатай байгаа нь аврах ажиллагааны техник хэрэгсэл хүрэлцэн очиход цаг хугацаа алдах, хэт өндөр барилгажилт, байр зүйн нам дор байршлаас тусгай зориулалтын автомашины богино долгионы холбооны хэрэгслийн сүлжээ сарних зэрэг асуудал нь дээрх хүчин зүйлээс хамаарч байна.

Зөвхөн нийслэл хотод 2015 онд үүссэн нөхцөл байдлын тоон үзүүлэлтээс авч үзэхэд нийт 3840 дуудлага бүртгэгдэж, үүнээс аврах ажиллагааны 460, объектын гал түймрийн 3353, ой хээрийн түймрийн 27 дуудлага[1]-аар нийслэлийн Онцгой байдлын газрын Гал унтраах, аврах ангийн хүч хэрэгсэл ажилласнаас үзэхэд мөн тухайн илтгэлд дурдагдаж байгаа үндэслэл нотолж байна.

Дээрхи дүн мэдээ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт дуудлагын тоо 8.9%-иар, объектын гал түймрийн тоо 8.7%-иар, аврах ажиллагааны тоо 6.2%-иар тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.

Энэ нь болзошгүй гамшгийн аюулын эрсдэлийг бий болгож, түүнээс улбаалж үлэмж их хэмжээний хохирол учрах, Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг сааруулж болзошгүй хүчин зүйл болоод байна. Иймд Улаанбаатар хотод болзошгүй аюулт үзэгдэл, ослын үеийн шуурхай удирдлага, зохицуулалтын зарим асуудлыг боловсронгуй болгох, энэ чиглэлд судалгаа хийх үндэслэл болж байгаа юм.

Тухайлбал нийслэл хотод өнгөрсөн онд буюу 2015 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Баянзүрх дүүргийн Шар хаднаас зүүн хойшоо Гүнжийн ам, Шар хоолойн ам гэх газарт 3.5 болон 4.4 магнитудын хүчтэй хоёр удаагийн газар хөдлөлтийн аюул, Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ‘Гранд повэр” ХХК-ийн нүүрсний хийн үйлдвэрт гарсан ослын улмаас 11 иргэн хорт хийнд хордож, 3 хүн нас барсан химийн осол зэрэг нь үүсч болзошгүй гамшгийн аюулд хүн ам, мал амьтан, байгаль экологи, хүрээлэн буй орчин, эд хөрөнгө өртөх магадлал өндөр байгаа тул энэхүү учирч болох гамшгийн хохирлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах явдал нь эн тэргүүний зорилго юм.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд болзошгүй гамшгийн үед хариу арга хэмжээ явуулах төдийгүй хохирлыг багасгах үүднээс шуурхай удирдлага, зохицуулалтын арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэх шаардлагатайг судлаач миний бие судалгааны ажлын хүрээнд тодорхой эх сурвалж болон судалгааны арга зүйд тулгуурлан хөндөх болно.

[1] НОБГ-ын 2015 оны жилийн эцсийн статистикийн тоо, судалгаа